



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 323

Улаанбаатар хот

Маягт батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 5, 69 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Үндэсний статистикийн хорооны даргын 2020 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн А/33 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн маягт, түүний нөхөх зааврыг 1 дүгээр, Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн захиргааны статистикийн маягт, түүний нөхөх зааврыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн болон захиргааны статистикийн маягт, түүний нөхөх зааврыг орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, мэдээллийн үйл ажиллагаанд мөрдөж ажиллахыг Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (З.Мэндсайхан), Нийслэлийн өмчийн ашиглалт удирдлагын газар болон аймгуудын Орон нутгийн өмчийн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1. Энэ тогтоолоор баталсан маягтуудыг төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн мэдээллийн тогтолцоог бүрдүүлэхэд ашиглаж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;

3.2. Энэ тогтоолын 2 дугаар хавсралтад заасан Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн захиргааны статистикийн маягтаар тайлан, мэдээ, мэдээллийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс жил бүр хүлээн авч холбогдох маягтыг заасан хугацаанд Үндэсний статистикийн хороонд хүргүүлж байх зохион байгуулалтын арга хэмжээ авах.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т даалгасугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2020 оны ... дугаар сарын
.....-ний өдрийн ... дугаар тогтоолын
нэгдүгээр хавсралт

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН
БҮРТГЭЛИЙН МАЯГТ, ТҮҮНИЙ НӨХӨХ ЗААВАР**

1. Хуулийн этгээдийн ерөнхий мэдээлэл (ТӨХ-1)
2. Байгууллагын эзэмшил /ашиглах/ газрын бүртгэл (ТӨХ-2)
3. Барилга байгууламжийн бүртгэл (ТӨХ-3)
4. Барилга байгууламжийн хийц, хэмжээсийн бүртгэл (ТӨХ-3.1)
5. Байгууллагын мэдлийн нийтийн эзэмшлийн байгууламжийн бүртгэл
(ТӨХ-4)
6. Машин тоног төхөөрөмжийн бүртгэл (ТӨХ-5)
7. Тээврийн хэрэгслийн бүртгэл (ТӨХ-6)
8. Тавилга, эд хогшил, бусад үндсэн хөрөнгийн бүртгэл (ТӨХ-7)
9. Үндсэн сүргийн мал, амьтадын бүртгэл (ТӨХ-8)
10. Худаг, услалтын системийн бүртгэл (ТӨХ-9)
11. Оюуны өмчийн бүртгэл (ТӨХ-10)
12. Үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн 20.....оны жилийн дэлгэрэнгүй
мэдээ (ТӨХ-11)

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2020 оны 07 дугаар сарын
06 ний өдрийн 30 дугаар тогтоолын
хоёрдугаар хавсралт

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН
ЗАХИРГААНЫ СТАТИСТИКИЙН МАЯГТ, ТҮҮНИЙ НӨХӨХ ЗААВАР**

1. Дуусаагүй барилга байгууламжийн 20.....оны жилийн бүртгэл (ТӨ-1)
2. Үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн 20.....оны жилийн мэдээ (ТӨ-2)
3. Биет бус хөрөнгийн бүртгэлийн 20.....оны жилийн мэдээ (ТӨ-3)
4. Түрээслүүлсэн үндсэн хөрөнгийн 20.....оны жилийн мэдээ (ТӨ-4)
5. Түүх, соёлын дурсгалт зүйлсийн 20.....оны жилийн мэдээ (ТӨ-5)
6. Улсын нэгдсэн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болгосон үндсэн хөрөнгийн 20.....оны жилийн мэдээ (ТӨ-6)
7. Гадаад зээлийн эх үүсвэрээр бий болгосон үндсэн хөрөнгийн 20.....оны жилийн мэдээ (ТӨ-7)
8. Гадаадын буцалтгүй тусламж, хандив, бэлэглэлээр бий болсон үндсэн хөрөнгийн 20.....оны жилийн мэдээ (ТӨ-8.1)
9. Дотоодын буцалтгүй тусламж, хандив, бэлэглэлээр бий болсон үндсэн хөрөнгийн 20.....оны жилийн мэдээ (ТӨ-8.2)
10. Бүртгэлд тусгаагүй үндсэн хөрөнгийн 20.....оны жилийн мэдээ (ТӨ-9)
11. Дутагдуулсан үндсэн хөрөнгийн 20.....оны жилийн мэдээ (ТӨ-10)
12. Маргаантай үндсэн хөрөнгийн 20.....оны жилийн мэдээ (ТӨ-11)
13. Илүүдэлтэй, ашиглагдаагүй байгаа үндсэн хөрөнгийн бүртгэлийн 20.....оны жилийн мэдээ (ТӨ-12)
14. Улсын чанартай авто замын 20.....оны жилийн мэдээ (ТӨ-13.1)
15. Улсын чанартай гүүрийн 20.....оны жилийн мэдээ (ТӨ-13.2)
16. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 20.....оны жилийн мэдээ (ТӨ-14)
17. Радио долгионы 20.....оны жилийн мэдээ (ТӨ-15)